



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 8 сарын 30 өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц,  
хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт  
оруулах зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигч У.Бямбасүрэнгийн эзэмшлийн 11.0 хувь буюу 38,500 ширхэг 385,000,000.0 /гурван зуун наян таван сая/ төгрөгийн хувьцааг хувьцаа эзэмшигч Б.Түвшинд худалдахыг, хувьцаа эзэмшигч Ж.Бат-Оршихын эзэмшлийн 4.0 хувь буюу 14,000 ширхэг 140,000,000.0 /нэг зуун дөчин сая/ төгрөгийн хувьцааг хувьцаа эзэмшигч Б.Түвшинд бэлэглэхийг, хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнд тооцогдсон халаасны хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчдэд эзэмшиж байгаа хувьцааны тоонд хувь тэнцүүлэн худалдан авахыг зөвшөөрч тус компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнийг энэхүү тогтоолын хавсралтад дурдсанаар өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Миг даатгал” ХХК /Ж.Бат-Орших/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

2017.08.30

Санхүүгийн зохицуулах хорооны  
2017 оны 8 дугаар сарын 29 өдрийн  
158 тоот тогтоолын хавсралт



“МИГ ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10,000.0 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10,000.0 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Б.Түвшин /ИВ75021210/	129,500	1,295,000,000.0	37.0%	727,220,000.0		202,222	2,022,220,000.0	57.78%
2	Ж.Бат-Орших /ЧС55031936/	63,000	630,000,000.0	18.0%		(85,560,000.0)	54,444	544,440,000.0	15.56%
3	У.Бямбасүрэн /ДБ72082693/	38,500	385,000,000.0	11.0%		(385,000,000.0)		-	-
4	С.Буйнхшиг /УУ91070729/	35,000	350,000,000.0	10.0%	38,890,000.0		38,889	388,890,000.0	11.11%
5	Н.Энхболд /ХП85090113/	28,000	280,000,000.0	8.0%	31,110,000.0		31,111	311,110,000.0	8.89%
6	Г.Лхамсүрэн /ЧС79031732/	14,000	140,000,000.0	4.0%	15,560,000.0		15,556	155,560,000.0	4.44%
7	Л.Цэцэг-Эрдэнэ /ЧС52030464/	7,000	70,000,000.0	2.0%	7,780,000.0		7,778	77,780,000.0	2.22%
8	“Миг даатгал” ХХК	35,000	350,000,000.0	10.0%		(350,000,000.0)		-	-
	<b>Нийт</b>	<b>350,000</b>	<b>3,500,000,000.0</b>	<b>100%</b>	<b>820,560,000.0</b>	<b>(820,560,000.0)</b>	<b>350,000</b>	<b>3,500,000,000.0</b>	<b>100%</b>